



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2025 оны 04 сарын 03 өдөр


Дугаар 143.

Улаанбаатар хот

Г Орон сууц хувьчлах товчоог шинэчлэн  
байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9, Орон сууц хувьчлах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Орон сууц хувьчлах товчооны ажиллах журмын 1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Говьсүмбэр аймгийн орон сууц хувьчлах товчоог хавсралтад заасан бүрэлдэхүүнтэй байгуулсугай.
2. Орон сууц хувьчлах тухай хууль тогтоомж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 67 дугаар тогтоолоор батлагдсан “Орон сууц хувьчлах товчооны ажиллах журам”-ыг мөрдөж ажиллахыг товчоонд үүрэг болгосугай.
3. Товчооны үйл ажиллагааны зардлыг зохих журмын дагуу тооцож, төсөвт тусган санхүүжүүлэхийг Говьсүмбэр аймгийн Засаг дарга (Т.Бат-Эрдэнэ)-д зөвлөсүгэй.
4. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 201 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.
5. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 04 дугээр сарын 03-ны өдрийн 143 дугаар тогтоолын хавсралт

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ОРОН СУУЦ ХУВЬЧЛАХ  
ТОВЧООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Товчооны дарга

Аймгийн Засаг дарга

Нарийн бичгийн дарга

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн

Гишүүд

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрхзүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

.....ооо.....